

**ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛИЙН**  
**9-р БАГЦЫН ТАВАНТОЛГОЙ ӨРТӨӨНИЙ 35/10 Кв ИЖ БҮРЭН ХУВААРИЛАХ**  
**БАЙГУУЛАМЖ, ДЭД СТАНЦ БОЛОН ШУГАМ БАРИХ**  
**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

**Улаанбаатар 2021**

**Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн  
Тавантолгой өртөөний 35/10 кВ иж бүрэн хуваарилах байгууламж, дэд станц болон  
шугам барих IX багцын ажил гүйцэтгэх гэрээ**

2021 оны 01 дугаар  
сарын 25-ний өдөр

№ ТХЗ-НУС/2021/003

Улаанбаатар хот

Энэхүү Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн Тавантолгой өртөөний 35/10 кВ иж бүрэн хуваарилах байгууламж, дэд станц болон шугам барих IX багцын ажил гүйцэтгэх гэрээ /Цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас: Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ыг төлөөлж Замын 1-р орлогч дарга Милостных И.В. (цаашид "Захиалагч" гэх),

Нөгөө талаас: Улсын бүртгэлийн 9011268100, Регистрийн 2881888 дугаартай "Вест-Энержи" ХХК түүнийг төлөөлж захирал албан тушаалтай А.Энхбаяр (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нар хүсэл, зориг, ашиг сонирхлоо бүрэн илэрхийлж, Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль бусад холбогдох хуулиуд болон Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйл заалтыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн байх зарчимд тулгуурлагдсан болохыг 2 тал харилцан хүлээн зөвшөөрөв.

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Гэрээний зорилго Дэд ажлын хэсгийн 2021 оны 01 дугаар сарын 25 ний өдрийн хуралдаанаас гарсан шийдвэр болох 162 дугаартай зөвлөмжийг үндэслэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн Тавантолгой өртөөний 35/10 кВ иж бүрэн хуваарилах байгууламж, дэд станц болон шугам барих IX багцын ажил гүйцэтгэх гэрээ ажлыг батлагдсан зургийн дагуу гэрээт ажлын дүнд багтаан ажлыг гүйцэтгэх, энэхүү гэрээгээр харилцан тохиролцсон ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахтай холбогдсон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн хүлээх үүрэг, эдлэх эрх болон хариуцлагыг тогтооход оршино.

1.2 Гэрээт ажил: Гэрээний хугацаанд энэхүү гэрээний 1.1-д заасан газарт хавсралт 1-д заасан ажлыг иж бүрэн хийж гүйцэтгэнэ.

1.3 Гэрээний нийт үнийн дүн: **2,357,503,195 /Хоёр тэрбум гурван зуун тавин долоон сая таван зуун гурван мянга нэг зуун ерэн таван/** төгрөг байна. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татвар, хураамжуудыг ГЕН-ийн 49 дэх хэсэгт заасны дагуу Гүйцэтгэгч нь хуульд заасан хэмжээгээр өөрөө хариуцан барагдуулна.

1.4 Гэрээний үнийн задаргааг Хавсралт №3-д заасан болно. Энэ үнэнд тоног төхөөрөмж, холбох хэрэгсэл, тэдгээрийг угсрах, суурилуулах болон материалын үнэ, ажлын хөлс, ажилт, тээврийн зардал, гааль болон татвар зэрэг холбогдох бүх зардал багтсан бөгөөд НӨАТ багтсан болно.

1.5 Дор дурдсан гэрээ, баримт бичиг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд эдгээрийн хамт энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр байна. Үүнд:

1.5.1 Гэрээ

1.5.2 Гэрээний ерөнхий нөхцөлүүд

1.5.3 Гэрээний тусгай нөхцөлүүд

1.5.4 Хавсралт 1 Ажлын зураг (Ажлын даалгавар)

1.5.5 Хавсралт 2 Ажлын төсөв (Зардлын задаргаа)

1.5.6 Хавсралт 3 Төлбөрийн хуваарь /Гүйцэтгэл баталгаажуулах хуваарь/

1.5.7 Хавсралт 4 Үе шатны ажлын хуваарь

1.5.8 Хавсралт 5 Ажлын график төлөвлөгөө

1.5.9 Хавсралт 6 Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн жагсаалт, ажиллах хүчний мэдээлэл,

1.5.10 Хавсралт 7 Үе шатны ажлын тайлан гаргах хуваарь

1.5.11 Хавсралт 8 Гэрээ дуусгавар болсны дараа хүлээлгэн өгөх бичиг баримтын жагсаалт

Энэхүү гэрээ нь торийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй агнаваа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

*(Харилцагчийн тэмдэг)*

1.5.12 Холбогдох бусад бичиг баримтууд /Гүйцэтгэгч компанийн гэрчилгээ тусгай зөвшөөрөл, итгэмжлэл, гэрчилгээ, захирал эсвэл эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэх г.м /нотариатаар баталгаажуулсан байна/.

## ХОЁР. НЭР ТОМЬЁО

Энэхүү Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1 "Гэрээ" гэж Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан энэхүү ажил гүйцэтгэх Гэрээг,

2.2 "Захиалагч" гэж "УБТЗ" ХНН;

2.4 "Гүйцэтгэгч" гэж "Вест-Энержи" ХХК-ийг;

2.5 "Санхүүжүүлэгч" гэж "МТЗ" ТӨХК-ийг;

2.6 "Зөвлөх хяналтын баг" гэж "Эрчим Хүчний Хөгжлийн төв" ТӨҮГ-ийг;

2.7 "Гэрээний үнэ" гэж Үйлчилгээг гүйцэтгэхэд зориулан Гүйцэтгэгч энэхүү Гэрээний 1.1-д заасны дагуу баталсан төсвийн үнийн дүнг;

2.8 "Гүйцэтгэх ажил" гэж Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөх энэхүү Гэрээний Хавсралт 1-д тодорхойлсон ажлыг;

2.9 "Ажил эхлэх өдөр" гэж Гүйцэтгэгчийн ажил эхлүүлэх өдрийг тус тус хэлнэ. Энэ өдрийг ГТН-ийн 1.1 дүгээр зүйлд заах бөгөөд ажлын талбайг эзэмших өдөртэй давхцаагүй байж болно.

2.10 "ГЕН" гэх товчилсон үгийг Гэрээний ерөнхий нөхцөл гэж ойлгоно,

2.11 "ГТН" гэх товчилсон үгийг Гэрээний тусгай нөхцөл гэж ойлгоно,

2.12 "Гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа" гэж Чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл хугацааг хэлнэ

## ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1 Захиалагч нь Гүйцэтгэгчийг гэрээний хавсралт 1-д заасан ажлыг үр дүнтэй, чанарын шаардлагын дагуу, хугацаандаа гүйцэтгэхэд хяналт тавих үүрэг хүлээнэ.

3.2 Захиалагч нь Гүйцэтгэгчийн хариуцсан инженерээс ирүүлсэн гүйцэтгэлийн үнэн зөв, алдаагүй байдалд хяналт тавьж баталгаажуулна.

3.3 Ажлын хэрэгжилт, ажлын явц, тайлан мэдээтэй чөлөөтэй танилцах, газар дээр нь үнэлгээ шалгалт хийх, шаардлага тавих эрхтэй.

3.4 Захиалагчийн инженерүүд нь зөвхөн гүйцэтгэсэн ажлыг хянаж, харин санхүүжилтийг "МТЗ" ТӨХК хариуцна.

3.5 Гүйцэтгэгч нь санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан, төслийн хэрэгжилт, ажлын гүйцэтгэлийн явцад зөрчил гаргасан тохиолдолд гүйцэтгэлийг баталгаажуулахгүй, улмаар гэрээг цуцлах эрхтэй.

3.6 Гэрээний үнийн дүнд гэрээний хавсралт 3 заасан ажлын даалгаварт заасан бүх ажлыг бүрэн гүйцэтгэж хийж гүйцэтгэх бөгөөд илүү гарсан аливаа зардалд Захиалагч хариуцлага хүлээхгүй болно.

3.7 Ажлын явцад Захиалагчийн зүгээс ажлын зураг, төсөлд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд үүнтэй холбоотой ямар нэг нэмэгдэл зардлыг Гүйцэтгэгчид төлөхгүй болно.

## ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

4.1 Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг болох хавсралт 1-д заасан ажлыг үр дүнтэй, батлагдсан зураг төслийн дагуу техникийн болон чанар, стандартын шаардлага ханган гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

4.2 Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт 1-д тодорхойлсон зураг төсөлд заасан ажлыг хийж гүйцэтгэх үүрэгтэй.

4.3 Гүйцэтгэгч нь ГТН-ийн 1.1 дүгээр зүйлд Захиалагчаас шаардаж буй хавсралт 1-д заасан ажил үүргийг хавсралт 2-т заасан зураг төсвийн дагуу гэрээнд заасан хугацааны дотор хийж гүйцэтгэх мэргэжлийн дадлага туршлагатай инженер, техникийн болон бусад ажилтнууд болон тоног төхөөрөмж, техникийн эх үүсвэртэй байна. Гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу ажлыг хийж гүйцэтгэхийг энэхүү гэрээгээр хүлээн зөвшөөрсөн байна.

4.4 Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан нөхцөл, болзолд нийцүүлэн хавсралт 1-д заасан ажлыг зохих ёсоор гүйцэтгэж, зөрчил доголдол гаргасан үед түүнийг яаралтай засах, арилгах үүргийг хүлээнэ.

4.5 Ажлын явцтай холбоотой мэдээ тайланг Захиалагчид гэрээний хавсралт 7-д заасан хугацааны дагуу тухай бүр хүргүүлэх үүрэгтэйгээс гадна ажлын явцын гүйцэтгэлийг 7 хоног бүрийн 5 дахь өдөр "Эрчим Хүчний Хөгжлийн төв" ТӨҮГ-аас баталсан маягтын дагуу бөглөн Захиалагч тал, Зөвлөх хяналтын баг болох "Эрчим Хүчний Хөгжлийн төв" ТӨҮГ-д өгч байх үүрэгтэй.

4.6 Санхүүжилт авахтай холбогдуулан хүргүүлсэн аливаа мэдээлэл, тайлан, нэхэмжлэхийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.

4.7 Гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээх үүргийг ГТН-ийн 6.0 дугаар зүйлд нарийвчлан заасан болно.

4.8 Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан нөхцөлийн дагуу дурдагдсан ажлыг гүйцэтгэх явц болон чанарын баталгаат хугацаанд гарсан эвдрэл гэмтлийг өөрийн зардлаар засах /солих/ үүрэг хүлээнэ.

4.9 ГТН-д өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь гэрээ байгуулахаас өмнө гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бүхий л шаардлагатай баримт бичиг, зөвшөөрөл, гэрчилгээг холбогдох эрх бүхий байгууллагаас авсан байх үүрэгтэй.

4.10 Дараах тохиолдолд Гүйцэтгэгч Захиалагчид санал гаргаж болно. Үүнд: Гүйцэтгэх ажил үүргийг гэрээнд заасан хугацаанаас өмнө дуусгахтай холбоотой, Гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг багасгахтай холбоотой, Гүйцэтгэх ажил үйлчилгээний үр дүнг сайжруулах тухай, ашигтай санал зэрэг болно.

#### ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс үүдэн гарах хариуцлагыг буруутай тал нь хариуцна.

#### ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

6.1 Энэхүү Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.2 Хэрэв тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд талууд уг маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХУЧИН ЗҮЙЛ

7.1 Давагдашгүй хүчин зүйлийн талаар ГЕН-ийн 28 дугаар зүйлд зааснаар ойлгоно.

#### НАЙМ. НУУЦЛАЛ

8.1 Гүйцэтгэгч нь Санхүүжүүлэгч, Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр бүхий л бичиг баримт, тоо мэдээлэл, олж авсан болон цуглуулсан мэдээллээ ямар нэг байдлаар гэрээний үүргийг биелүүлэхээс бусад тохиолдолд олшруулах, нийтэд тараах, нийтлэх, задруулах эрхгүй.

8.2 Энэхүү үүргээ биелүүлээгүйгээс Захиалагчид ямар нэг хохирол учирсан тохиолдолд хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулна.

8.3 Гэрээний ерөнхий нөхцөлийн 62 дугаар зүйлийн 62.2-т зааснаас гадна энэхүү гэрээг тендерт оролцох, банкны зээлд хамрагдах болон бусад зорилгоор олшруулж, хувилж нийтэд тараасан тохиолдолд Төрийн болон албаны нууцын тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээс гадна гэрээг шууд цуцлах үндэслэл болно.

#### ЕС. БУСАД

9.1 Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Гэрээний хавсралт, нэмэлт Гэрээнүүд нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

9.2 Талууд ГЕН-ийн 4 дэх хэсэгт заасны дагуу Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэх бөгөөд эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр гэж тооцогдох ба энэхүү Гэрээний салшгүй хэсэг байна.

9.3 Гэрээнд заасан үүрэг биелэгдсэнээр ГЕН-ийн 52, 53 дахь хэсэгт заасны дагуу гэрээ дуусгавар болно.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

9.4 Гэрээг 2 эх хувь үйлдэх ба хууль зүйн хувьд адил хүчин төгөлдөр байна. Гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа нь чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл хугацаанд үйлчилнэ.


9.5 Гэрээтэй холбостой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, албан бичгийг дараах хаягаар хүргүүлнэ. Хаяг өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухай бусад Талууддаа мэдэгдэх нь Талуудын үүрэг ба ийнхүү мэдээлээгүйгээс үүсэх хариуцлагыг тэдгээрийн хүргүүлсэн Тал хариуцахгүй болно.

9.6 Талууд гэрээний бүх заалттай бүрэн танилцаж маргаангүй болохыг нотолж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН  
БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“УБТЗ” ХНН-ийн Замын 1-р орлогч дарга



/МИЛОСТНЫХ И.В./

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“Вест-Энержи” Х.ХК-н захирал



/А.ЭНХБАЯР/

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН 2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДРИЙН  
315 ДУГААР ТУШААЛААР БАЙГУУЛАГДСАН  
ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН ЗӨВЛӨМЖ

2021 оны 01 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар № 169

Улаанбаатар хот

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК,  
“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” ХНН-д

Дэд ажлын хэсгийн 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийг үндэслэн ЗӨВЛӨМЖЛӨХ нь:

1. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар Төмөр Зам” нийгэмлэгээс ирүүлсэн саналыг үндэслэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн ПК416+160-ПК0+00 хооронд байрлах № 4, 5, 6 зөрлөгийн 35 кВ хуваарилах байгууламж, дэд станц барих VIII - р багц ажил, Тавантолгой өртөөний 35/10 кВ иж бүрэн хуваарилах байгууламж, дэд станц болон шугам барих IX – р багц ажлыг дараах компаниар гүйцэтгүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

№	Гүйцэтгэгч компани	Багц ажлын дугаар	35 кВ хуваарилах байгууламж, дэд станц, шугам барих	Багц ажлын нийт дүн / төг /
1.	“Катод гал” ХХК / РД - 5052408 /	VIII / 35 кВ хуваарилах байгууламж /	№ 4, 5, 6 зөрлөгийн 35/0.4 кВ хуваарилах байгууламж, дэд станц	2 719 850 000
2.	“Вести Энержи” ХХК / РД - 2881888 /	IX / 35/10 кВ хуваарилах байгууламж, дэд станц, шугам /	Тавантолгой өртөөний 35/10 кВ хуваарилах байгууламж, дэд станц болон шугам	2 357 503 195

2. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар Төмөр Зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дарга / Д. Жигжиднямаа /, “Монголын Төмөр Зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал / Р. Батсүх / - нарт холбогдох хууль тогтоомжид нийцүүлж эдгээр компаниудтай гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана уу. Гэрээт ажлын төлбөрийг гүйцэтгэлээр санхүүжүүлэх буюу эсвэл банкны баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөр олгох асуудлыг гэрээнд тусгахыг зөвлөмжилж байна.

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:

/...../

Д. ГАНЗОРИГ

ГИШҮҮД:

/...../

Б. МӨНХБАЯР

/...../

Э. БАТБАЯР

*Ц.Батзул* /...../

Ц. БАТЗУЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА :

*Б.Энэрэлт* /...../

Б. ЭНЭРЭЛТ

88084697 - "Катод гол" ХХК

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

НУУЦ

Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно:

Үндсэн Гэрээний 1.5-т заасан хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

### Гэрээний мэдээлэл

- 1.1 Захиалагч: “УБТЗ” ХНН  
Милостных И.В  
Утас:  
Факс:  
Майл хаяг: tusul.ubtz@gmail.com
- 1.1 Гүйцэтгэгч: “Вест-Энержи” ХХК  
А.Энхбаяр.  
Хариуцан ажиллах хүний нэр хаягийг тодорхой бичих /энэ хүн байхгүй байгаа тохиолдолд орлохоор өөр хүний нэр давхар бичих/  
Утас:  
Факс: 99116887  
Хаяг: Сүхбаатар, 10-р хороо, 7-р хороолол, 22-12 тоот  
Майл хаяг: dagii\_a11@yahoo.com
- 1.1 Ажил эхлэх өдөр 2021.02.15
- 1.1 Ажил дуусах өдөр 2021.06.01
- 1.1 Ажлын талбай нь Тавантолгой өртөөний 35/10 кВ иж бүрэн хуваарилах байгууламж, дэд станц болон шугам барих ажлыг зураг хавсралт 1-д зааснаар ажлын талбай хүртэл зайн хэмжээгээр тодорхойлогдсон болно.
- 1.1 Гүйцэтгэгч нь гэрээний хавсралт №6 санал болгосон хүнд машин механизм тусгай тоног төхөөрөмжийг зөвхөн энэхүү гэрээт ажилд ашиглана. Ажлын талбайд аваачсан тоног төхөөрөмж, хүнд машин механизмыг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр авч явахыг хориглоно.
- 1.1 Гүйцэтгэгч нь гэрээт ажилд батлагдсан зургийн дагуу Захиалагч болон Зөвлөх-Хяналтын багийн хүлээн зөвшөөрсөн материал, бүтээгдэхүүнийг /техникийн шаардлага, тодорхойлолтод нарийвчлан заасан/ хэрэглэнэ. Барилгын материал, бүтээгдэхүүн нь Барилгын тухай хууль, Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам тогтоомжид заасан чанар, техникийн шаардлагыг бүрэн хангасан байна.
- 1.1 Зургийн автар болох “Эрчим Хүчний Эдийн Засгийн Хүрээлэн” ТӨҮГ-аас гаргасан “Зохиогчийн хяналтын дүгнэлт”-нд тусгагдсан заалтыг нэг бүрчлэн хэрэгжүүлж зөрчилг дутагдлыг тухай бүрд нь арилгаж ажиллах.  
Ажил гүйцэтгэхэд шаардлагатай инженер, техникийн болон бусад ажилтны жагсаалтыг гэрээнд хавсаргах ба энэ гэрээний салшгүй хэсэг байна.
- 3.0 Гэрээ Монгол хэл дээр 2 хувь байгуулагдсан.
- 4.0 Гэрээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд байгуулсан бөгөөд түүнд заасны дагуу ойлгож, тайлбарлагдана. Гэрээнд заагаагүй бусад асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 6.0 Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг:
  - 6.1 Ажлыг гэрээнд заасан хугацаа, нөхцөлөөр, өөрийн хөрөнгө, багаж, техник хэрэгсэл, ажиллах хүчийг ашиглан, чанарын өндөр түвшинд, алдаа дутагдал, доголдолгүй хийж гүйцэтгэн Захиалагч, Техникийн болон Улсын комисст ажлын гүйцэтгэлийг актын дагуу хүлээлгэн өгөх,

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.



- 6.2 Ажлын гүйцэтгэлийн явцыг 7 хоногт 1 удаа "Эрчим Хүчний Хөгжлийн Төв" ТӨҮГ-аас гаргасан загварын дагуу тайланг ЭХХТ, Захиалагчид фото зургаар баталгаажуулж гаргаж өгнө.
- 6.3 Захиалагч түүний төлөөлөгч Инженер болон бусад эрх бүхий этгээдээс ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан гаргасан санал, заавар, шаардлага, дүгнэлтийг хүлээн авах, биелүүлэх, ажилдаа тусгах, алдаа дутагдлаа залруулах.
- 6.4 Ажлын гүйцэтгэлийн үед гүйцэтгэсэн ажил нь гологдол, дутагдалтай, Захиалагчийн шаардлагад нийцэхгүй. Гэрээнд заасан зорилгоор ашиглах боломжгүй буюу тээвэрлэлтийн техникийн шаардлага аюулгүй ажиллагааг хангахгүй байна гэж Захиалагч үзвэл Гүйцэтгэгч түүний тогтоосон хугацаанд өөрийн зардлаар засах буюу гэрээнд заасан зориулалтаар ашиглагдах нөхцөлийг хангах.
- 6.5 Ажлын гүйцэтгэл, үр дүнгийн чанар, стандартын шаардлага, аюулгүй байдал, доголдолгүй, бүрэн гүйцэт байдлыг Захиалагч болон аливаа гуравдагч этгээдийн өмнө бүрэн хариуцах.
- 6.6 Гэрээгээр хүлээсэн үүргээ /түншлэлийн компанид хамаарахгүй/ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх.
- 6.7 Монгол Улсын Эрчим Хүчний сайдын 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 102 тоот тушаалаар батлагдсан "Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм"-ийг чанд мөрдөж ажиллах.
- 6.8 Ажлыг гүйцэтгэх явцад эрчим хүч, зам, барилга, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, замын хөдөлгөөний дүрэм, журам, өргөх зөөх машин механизмын норм, стандарт, шаардлагыг бүрэн биелүүлж Захиалагчийн болон бусад эрх бүхий байгууллагын ажилтнуудын заавар, зөвлөмжийг мөрдөж ажиллах бөгөөд эдгээр шаардлагыг хангаагүйгээс ажлын гүйцэтгэл саатсан, эрх бүхий этгээд ажлыг зогсоосон бол үүнээс шалтгаалан Захиалагч болон бусдад учирсан бүх хохирол зардлыг хариуцах.
- 6.9 Ажил гүйцэтгэх явцад аюулгүй ажиллагааг хангаагүй, гүйцэтгэж буй ажилдаа болгоомжгүй, хайнга хандсан, ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, холбогдох стандарт, дүрэм, журмыг мөрдөөгүй, санаатай болон санамсар болгоомжгүйгээс өөрийн ажилтнууд, захиалагч болон 3-дагч этгээдийн бие махбод болон эд хөрөнгөнд ямар нэг хохирол учруулсан тохиолдолд хохирлыг бүрэн хариуцах бөгөөд энэ асуудал дээр Захиалагч ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.
- 6.10 Ажлыг гүйцэтгэх үедээ ашигласан зам, талбай, байгууламж, ажлын талбай, тэдгээрийн ойр орчимд чулуу, шороо, барилгын материалын үлдэгдэл зэрэг хог хаягдал хаяхгүй, асгахгүйгээр цэвэр цэмцгэр хийж гүйцэтгэх, орчин тойрныг бохирдуулахгүй байх, хог хаягдлыг өөрийн зардлаар тээвэрлэж холдуулах.
- 6.11 Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор талбай чөлөөлөх, бусдын ашиглалтад байгаа инженерийн шугам сүлжээ, зам, талбай, барилга байгууламж, ургамал, тарьцыг зайлуулах сэтлэх, холболт хийх үедээ бусад этгээдийн ашиг сонирхол хохирол учруулахаас сэргийлэх, шугам сүлжээ, зам талбай, барилга байгууламж, ургамал тарьцыг урьд байсан нөхцөлийг муутгахгүйгээр цэвэр, өнгө үзэмжтэй байдалд нь сэргээж өгөх.
- 6.12 Ажлыг гүйцэтгэхдээ ашиглаж буй түүхий эд, материал, тоног төхөөрөмж нь гэрээний хавсралт 1-т заасан техникийн шаардлагыг бүрэн хангасан байх.
- 6.13 Ажил гүйцэтгэхдээ галын аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан материалыг ашиглах.
- 6.14 Насанд хүрээгүй хүүхэд ажлын талбарт нэвтрүүлэхгүй, ажиллуулахгүй байх.
- 6.15 Болзошгүй, гэнэтийн аюул, байгалийн гамшиг, осол аваарын үед ажиллах, эрсдэлээс сэргийлэх, ажлын явцыг түргэн шуурхай сэргээх тусгай төлөвлөгөө баталж, байнгын бэлэн байдлыг хангаж ажиллах.
- 6.16 35 кВ хуваарилах байгууламж, дэд станц угсрах, шугам барих ажил гүйцэтгэхтэй холбоотой аюул, осол, байгалийн гамшиг зэрэг онцгой нөхцөл байдлын үед Захиалагч болон холбогдох бусад этгээдтэй хамтран ажиллаж, шаардлагатай тусалцаа, дэмжлэгээр хангаж, тэдний зааварчилгааг, төлөвлөгөөг мөрдөж ажиллах.

- 6.17 Ажлын гүйцэтгэлд ашиглаж буй машин механизм, техник хэрэгслийн бүрэн бүтэн, аюулгүй, хэвийн ажиллагааг байнга хангах,
  - 6.18 Гүйцэтгэгч ажлын хуваарьт хугацаандаа багтаагүйгээс эсвэл өөрсдийн хүсэлтээр хяналт хийлгэх тохиолдолд Захиалагчийн Инженерийн хөлсийг бүрэн хариуцах,
  - 6.19 Гэрээний дагуу бэлтгэх, танилцуулах ёстой ажлын төлөвлөгөө, ажил гүйцэтгэх аргачлал, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тайлан, зардалтай холбоотой бичиг баримтууд, мэдээлэл болон Захиалагчаас шаардсан зүйлийг цаг хугацаанд гаргаж өгөх,
  - 6.20 Ажлын талбай дээрх бүх аюулгүй ажиллагааг бүрэн хариуцах бөгөөд аюулгүй ажиллагааг хангаагүйгээс үүдэн гарсан аливаа асуудлыг бүрэн хариуцна.
  - 6.21 35 кВ хуваарилах байгууламж, дэд станц угсрах, шугам барих ажлын талбайн ойр орчмын хаалт, хамгаалалт, байгууламжуудыг эвдэж гэмтээхгүй байх, тэмдэг тэмдэглэгээ, схем зураг, санамжийг дагаж мөрдөх, анхаарал болгоомжтой хандах,
  - 6.22 35 кВ хуваарилах байгууламж, дэд станц угсрах, шугам барих ажлын талбайд аюултай хүчин зүйлүүд тохиолдож болзошгүй бүсийг урьдчилан сэргийлэх болон дохио, санамж, анхааруулга, аюулгүйн тэмдэг бүхий хаалт хамгаалалтаар хашиж тусгаарласан байх;
  - 6.23 Хэрэв шөнийн цагаар ажил гүйцэтгэх тохиолдолд барилга угсралтын ажлын талбайн гэрэлтүүлэг нь ажиллагсдын ажиллах нөхцөлийг бүрэн хангахуйц бүх талбайг жигд, нүд гялбахгүйгээр тод гэрэлтүүлж байх;
  - 6.24 Монгол улсын хууль тогтоомж болон ёс заншлыг дагаж мөрдөх,
  - 6.25 Энэхүү үүргийн 6.24-ийг ноцтой зөрчсөн ажилтныг тухайн гэрээт ажил дээр ажиллуулахгүй байх арга хэмжээг нэн даруй авах,
  - 6.26 Ажлын талбарт Захиалагч болон захиалагчийн инженер хяналт тавих, үзлэг шалгалт хийхээр ирэх үед гүйцэтгэгчийн зүгээс аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулж ажиллана. Захиалагч болон захиалагчийн инженер нь ажлын талбарт нэвтрэхдээ гүйцэтгэгчийн тавьсан аюулгүй ажиллагааны бүх шаардлагыг биелүүлнэ;
8. Гүйцэтгэгч: **“Вест-Энержи” ХХК**
- 9.1 Түншлэл: байхгүй
- 11.0 Ажил гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах хүчний жагсаалтыг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 15.0 Даатгалыг ГЕН-ийн 15-ийн 15.1-д заасан нөхцөлүүдээр даатгагдсан байна.
- 18.0 Техникийн стандарт: Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох стандартуудыг энэ төслийн зураг төсөл болон барилгын ажлын гүйцэтгэлд дагаж мөрдөнө. Монгол Улсын стандартад байхгүй тохиолдолд Улаанбаатар хотын ижил төстэй уур амьсгалтай бүс нутгийн ..... стандартыг авч хэрэглэнэ.
- 19.0 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: 2021.06.01
- 21.1 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх хугацаандаа санаатай болон санамсар болгоомжгүйгээс өөрийн ажилтнууд, Инженер, Захиалагчийн нэрийн өмнөөс хяналт тавьж буй ажилтнууд болон 3-дагч этгээдийн бие махбод болон эд хөрөнгөнд ямар нэг хохирол учруулсан тохиолдолд хохирлыг бүрэн хариуцах бөгөөд энэ асуудал дээр Захиалагч ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Өөрөөр хэлбэл Гүйцэтгэгч нь Захиалагчийг шүүх, хууль хяналтын маргаантай холбоотой асуудлаас ангид байлгах үүргийг хүлээж байгаа гэдгээ үүгээр баталгаажуулж байгаа болно.
- 23.0 Ажлын талбайг ашиглуулж эхлэх өдөр: 2021.02.15

Газар чөлөөлөх: Захиалагч нь ажлыг талбай дээр байгаа байшин барилга, байгууламжуудыг чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх, хамгаалах асуудлуудыг хариуцна.

Гүйцэтгэгч нь газар доорх инженерийн шугам сүлжээг чөлөөлөх, шилжүүлэх, хамгаалах ажлыг хариуцан гүйцэтгэнэ. Үүнд: цахилгаан, холбоо, дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээ, борооны ус зайлуулах байгууламж, гэрэлтүүлэг гэх мэт багтана. Энэ ажилтай холбоотой гарах бүх зардлуудыг гүйцэтгэгч хариуцна.

- 29.0 Гүйцэтгэгч гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын графикийг гаргана.
- 29.0 Шаардлагатай тохиолдолд ажлын графикийг 30 хоног тутамд тодотгоно.
- 29.0 Тодотгосон ажлын графикийг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд суутгах үнийн дүн нь 10,000,000 /Арван сая/ төгрөг байна. Энэхүү төлбөрийг Гүйцэтгэгч Захиалагчид төлнө.
- 36.0 Чанарын баталгаат хугацаа 4 жил байна. /Улсын комисс хүлээн авсны дараа гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэж үзэн Гүйцэтгэгч, Захиалагч гэрээ дүгнэсэн акт үйлдэж албан ёсоор баталгаажуулсан өдрөөс хойш/
- 43.0 Санхүүжүүлэгч гэрээний хавсралт 3-т заасан хуваарийн дагуу хавсралт 5-д заасан ажлын гүйцэтгэлтэй уялдуулан төлбөрийг төлнө. Дээрх төлбөрийн хэмжээ Гэрээний хэрэгжилтийн хугацаанд тогтмол байх ёстой.

Гүйцэтгэгчийн хүргүүлсэн эцсийн тайлан болон сүүлчийн төлбөрийн мэдэгдлийг Захиалагч хүлээн зөвшөөрч хангалттай гэж дүгнэсний дараагаар Санхүүжүүлэгч эцсийн төлбөр тооцоо хийнэ. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаар тайлбарыг 10 хоногийн дотор гаргаж Гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол Санхүүжүүлэгч, Захиалагч төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

Төлбөр хийх хугацаа нь төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш дараах хугацааны дотор байна. Үүнд:


- 43.4 Инженер Гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийг хүлээн аваад холбогдох ажлын тайлан эд материалын нэхэмжлэлээр баталгаажуулан 14 хоногийн дотор Санхүүжүүлэгчид хүргүүлнэ.
- 43.5 Санхүүжүүлэгч, Захиалагч нь төлбөрийн мэдэгдлийг холбогдох баримт материалын хамтаар хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногт багтаан хянан батлах ёстой.
- 43.6 Санхүүжүүлэгч нь үүний дараа ажлын ..... хоногт төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөр хийхдээ зайлшгүй дагалдах ёстой санхүүгийн болон бусад баримт бичгийг хавсаргаагүй хэсгийн төлбөрийг хийхийг түдгэлзүүлж болно.
- 44.0 Санхүүжүүлэгч нь төлбөрийг Гүйцэтгэгчийн Төрийн банкны 106000054944 тоот дансанд шилжүүлнэ.
- 45.0 Гэрээний үнэ гэрээний хүчинтэй хугацааны дотор тогтмол байна. Үнэ ямар нэг байдлаар өөрчлөгдөхгүй. Гэрээний гүйцэтгэл нь нийт төсөвт өртгөөс бага байх тохиолдолд төлбөрийг гүйцэтгэлээр нь олгоно. /Гүйцэтгэл нь гэрээний үнийн дүнгээс бага байх тохиолдолд/
- 47.0 Төлбөрийг төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 48.0 Чанарын баталгаат хугацаанд гарсан доголдол, зөрчлийг арилгуулахтай холбоотой зардал гэж гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувийг чанарын баталгаат хугацаа дуусах хүртэлх хугацаанд Гүйцэтгэгч баталгаа хөрөнгө болгон үлдээнэ.

- 49.0 Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн 0,5 хувь байна.
- 49.0 Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувь байна
- 49.0 Торгууль ногдуулах хэмжээ гэрээний нийт үнийн дүнгийн 2 хувь байна.
- 50.0 Урьдчилгаа төлбөрийг банкны баталгааг үндэслэн гэрээний нийт дүнгийн 30 хувиас хэтрүүлэхгүйгээр олгоно. Урьдчилгаа төлбөр нь зөвхөн тээврийн болон нүүлгэн шилжүүлэлтийн зардал, материал худалдан авах, хүнд машин механизм, тоног төхөөрөмж худалдаж авах, түрээслэх зардалд зориулж олгоно. Урьдчилгаа төлбөрийг энэхүү зориулалтаас өөрөөр ашиглахыг хориглоно.
- 51.0 Гүйцэтгэлийн баталгаа байхгүй
- 53.0 Доорх үйл ажиллагаанаас үүсэх Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас хамааран гарсан аливаа зардал, төлбөр, алдагдал, хураамж зэргийг гүйцэтгэгч хариуцан арилгана. Үүнд:  
Гүйцэтгэгчийн гэрээт ажилтнууд болон захиалагч 3-дагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол  
Захиалагч болон бусад 3-дагч этгээдийн эд хөрөнгөнд учирсан аливаа хохирол  
Гэрээний дагуу гүйцэтгээгүй үүрэг болон гүйцэтгэсэн ажлын доголдол, зөрчил, дутагдал  
Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад аливаа нэг хохирол болон алдагдал хүлээсэн тохиолдолд түүний буруутай эсэхээс үл хамааран хохирлыг заасан хэмжээгээр өөрөө барагдуулна.  
Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ заасан хугацааны дотор гүйцэтгээгүйгээс шалтгаалан ханшны өөрчлөлтийн улмаас бараа материал, сэлбэг хэрэгсэл, шатах, тослох материал г.м-ийн үнэ өсөх зэрэг захиалагчид гарах энэхүү нэмэлт зардлыг бүрэн хариуцна.
- 54.0 ГЕН-ийн 54-т заасан төлбөрийг шилжүүлснээр гэрээ дуусгавар болно.
- 55.0 Гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, Инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан актыг Ажил дууссан тухай мэдэгдлийн хамт 5 хоногийн дотор гаргаж өгнө.
- 55.0 Дээрх материалыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ **10,0 сая төгрөг** байна.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН  
БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.



**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**


“УБТЗ” ХНН-ийн Замын 1-р орлогч дарга

  
.....МИЛОСТНЫХ И.В./

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“Вест-Энержи” ХХК-н захирал

  
...../А.ЭНХБАЯР/  




ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

А. ЕРӨНХИЙ ЗААЛТ

1. Нэр томьёо

1.1. Энэ Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

“Үе шатны ажлын хуваарь /ажлын тоо хэмжээ/” гэж Гүйцэтгэгчээс үе шатны ажил /ажлын тоо хэмжээ/-ын үнийг тусгаж ирүүлсэн хуваарийг;

“Гэрээнд хэрэглэх хууль” гэж энэхүү гэрээ, түүний утга, агуулгыг тайлбарлаж буй Монгол улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж болон бусад эрх зүйн актыг хэлнэ

“Ажил дууссан өдөр” гэж гэрээнд заасан хугацаанд ажил дууссаныг Захиалагч баталгаажуулсан өдрийг; Баталгаажуулах хэлбэр нь талуудын албан ёсны гарын үсэг зурж, тамга тэмдэг бүхий ажил хүлээлцсэн акт, протокол байна

“Гэрээ” гэж Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулсан энэхүү ажил гүйцэтгэх Гэрээг,

“Захиалагч” гэж “ Улаанбаатар Төмөр Зам” ХНН-ийг

“Гүйцэтгэгч” гэж “Вест-Энержи” ХХК-ийг;

“Санхүүжүүлэгч” гэж “Монголын Төмөр Зам” ТӨХК-ийг

“Зөвлөх-Хяналтын баг” гэж “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ийг

“Зураг зохиогч” гэж батлагдсан зураг төсвийг гүйцэтгэсэн “Эрчим Хүчний Эдийн Засгийн Хүрээлэн” ТӨҮГ-ийг

“Гэрээний үнэ” гэж үндсэн гэрээний 1.3 дугаарт заасан үнийг,

“Хоног” гэж хуанлийн хоногийг, сар гэж хуанлийн сарыг хэлэх ба хоногийг Монгол Улсын иргэний хуульд зааснаар тооцно;

“Зөрчил, доголдол” гэж зураг төсөл, техникийн шаардлагыг зөрчсөн, чанарын доголдол гаргасан буюу ажлыг гэрээнд заасны дагуу хийж, гүйцэтгээгүй байхыг

“Зөрчил, доголдол арилгасан тухай мэдэгдэл” гэж Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг арилгасныг үндэслэн Инженерийн гаргасан баталгааг;

“Чанарын баталгаат хугацаа” гэж ГТН-ийн 36 дүгээр зүйлд заасан ажлын үр дүн хүлээн авсан өдрөөс эхлэн тоологдох хугацааг хэлнэ. Энэ хугацаанд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч нь өөрийн зардлаар арилгах үүрэгтэй.

“Зураг” гэж батлагдсан зураг төсөл болон түүнтэй холбоотойгоор Зураг төсөл зохиогчийн гаргасан, баталсан тооцоо, бусад мэдээллийг;

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

**“Инженер”** гэж Захиалагчийн чиглэл хариуцсан инженер, эрчим хүчний инженер хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлж буй этгээдийг

**“Тоног төхөөрөмж”** гэж ажил гүйцэтгэх зорилгоор ажлын талбайд түр хугацаагаар авчирсан Гүйцэтгэгчийн машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тээврийн хэрэгслийг;

**“Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр”** гэж гэрээнд Гүйцэтгэгч ажлыг дуусгахаар заасан өдрийг хэлнэ. Зөвхөн Захиалагч тал хугацаа сунгах, эсхүл хурдасгах захиалга өгснөөр ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг;

**“Материал”** гэж ажлын зорилгоор Гүйцэтгэгчийн ашиглах бүх төрлийн материал, түүхий эд, хийц, бүтээгдэхүүн, эд анги болон бусад зүйлсийг;

**“Байгууламж”** гэж ажлын механик, цахилгаан, хими, эсхүл биологийн үйл ажиллагаа бүхий (функцтэй) бүрдэл хэсгийг;

**“Ажлын талбай”** гэж ГТН-ийн 1.1 дугаар зүйлд тодорхойлсон газрыг;

**“Ажлын талбайн судалгааны тайлан”** гэж ажлын талбайн гадаргуу, хөрс, цаг уурын нөхцөл, байгаль орчны үнэлгээ зэргийн талаар бодит байдлыг дурдаж тайлбарлаж хавсаргасан тайланг;

**“Техникийн шаардлага”** гэрээний зураг төсөлд заасан ажлын техникийн тодорхойлолтыг

**“Ажил эхлэх өдөр”** гэж Гүйцэтгэгчийн ажил эхлүүлэх өдрийг хэлнэ. Энэ өдрийг ГТН-ийн 1.1 дугаар зүйлд заасан бөгөөд ажлын талбайг эзэмших өдөртэй давхцаагүй байж болно.

**“Гүйцэтгэгч”** гэж гэрээнд тусгагдсан ажлын тодорхой хэсгийг хийхээр Захиалагчтай гэрээ байгуулсан хуулийн этгээдийг;

**“Туслах ажил”** гэж Гүйцэтгэгч ажлыг барьж байгуулах, суурилуулахад шаардлагатайн улмаас төлөвлөж, барьж, суурилуулж, зайлуулсан ажлыг;

**“Өөрчлөлт”** гэж ажилд өөрчлөлт оруулах талаар зураг төсөл зохиогчийн албан ёсоор зөвшөөрсөн өөрчлөлтийг;

**“Ажил”** гэж гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэж Захиалагчид хүлээлгэн өгөх гэрээний хавсралт 1-д тодорхойлсон ажлыг;

**“Ашиг сонирхлын зөрчил”** гэж Захиалагч, Гүйцэтгэгч, талуудын чиглэл хариуцсан инженерийн хооронд үүсэх ашиг сонирхлын зөрчлийг;

**“Авлига, хээл хахууль”** Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тодорхойлсноор;

“Магадлашгүй ажил” гэж ажил гүйцэтгэх явцад зураг төсөл, техникийн бичиг баримтад тусгагдсан шийдэл ба объектын барилгын ажлын нөхцөлд нарийвчилсан дүн шинжилгээ тооцоог хийсний дүнд зайлшгүй хийгдэх нэмэлт ажлыг;

“Магадлашгүй ажил”-ын зардал гаргахгүй байх, зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд “ Эрчим Хүчний Эдийн Засгийн Хүрээлэн” ТӨҮГ, “Монголын Төмөр зам” ТӨХК, “Эрчим Хүчний Хөгжлийн Төв” ТӨҮГ, Захиалагчаас холбогдох зөвшөөрлийг авч “магадлашгүй ажил”-ын төсвийг “Монголын Төмөр зам” ТӨХК-аар батлуулсны дараа ажил гүйцэтгэх бөгөөд холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл аваагүй тохиолдолд гарсан зардлыг гүйцэтгэгч хариуцна.

## 2. Тайлбар

- 2.1. Энэхүү гэрээний ерөнхий нөхцөлд ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно. Гарчигт гол ач холбогдол өгөхгүй. Онцгойлон заагаагүй бол гэрээний үгийг шууд утгаар нь хэрэглэнэ. Гэрээний нөхцөлийн талаарх тодруулга, тайлбарыг талууд чиглэл хариуцсан инженерээс гаргуулна.
- 2.2. Хэрэв гэрээний хавсралт 4,5-д заасан ажлыг үе шатаар буюу хэсэгчлэн дуусгахаар заасан бол гэрээний ерөнхий нөхцөл дэх ажил, ажил дууссан өдөр, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр гэсэн нэр томъёонууд (бүх ажилд хамааралтай ажил дуусгах өдөр болон ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр гэсэн нэр томъёоноос бусад) нь ажлын хэсэг бүрд хамаарна.
- 2.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол гэрээгээр хүлээсэн ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотой бүхий л зөвшөөрөл, эрхийн гэрчилгээ, хориглоогүй тухай эрх бүхий албан тушаалтнаас авах зөвшөөрлийг гүйцэтгэгч гэрээ байгуулахаас өмнө авах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь гэрээгээр гүйцэтгэх үүрэгт шаардлагатай бүхий л зөвшөөрлийг олж авах, татвар төлөх “үүнд зөвшөөрөл эзэмших төлбөр зэрэг мөн орно” түүнтэй холбоотой бүхий л ажиллагааны зардлыг өөрөө төлнө.
- 2.4. Зөвхөн дараах тохиолдолд л Гүйцэтгэгч Захиалагчид санал бичиж болно. Үүнд: Гүйцэтгэх ажил үүргийг хурдан дуусгахтай холбоотой, Гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг багасгахтай холбоотой, Гүйцэтгэх ажил үйлчилгээний үнэ цэнэ, үр дүнг сайжруулах тухай. Ашигтай санал зэрэг болно.
- 2.5. Хэрэв Гүйцэтгэгчээс Захиалагчид санал хүргүүлж байгаа бол дараах зүйлсийг бичсэн байна. Үүнд:  
Санал болгож буй загварын мэдээлэл ашиглагдах заавар  
Гүйцэтгэгчийн гэрээний үүргийг хурдан хугацаанд гүйцэтгэх тухай төлөвлөгөөнд оруулах шаардлагатай мэдээлэл.  
Гүйцэтгэгчийн саналын төсөв зэрэг болно.

## 3. Гэрээний хэл ба хууль

- 3.1. Энэхүү Гэрээ нь монгол хэл дээр байгуулагдсан. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь монгол хэл дээр байна. ГТН-ийн 3-д өөрөөр заагаагүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно. Гэрээнд заагаагүй бусад асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

4. Гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл 4.1. Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий албан тушаалтан эсхүл итгэмжлэгдэн томилогдсон этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны дагуу хэдийд ч нэмэлт өөрчлөлт оруулж болно. Тэрхүү нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.
5. Инженерийн шийдвэр 5.1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг заавал Захиалагчтай зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.
6. Үүрэг, хариуцлага 6.1. Гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр ямар ч тохиолдолд өөрийн ажил үүргээ өөр туслан гүйцэтгүүлэгчээр хийлгэх эрхгүй. Энэ тохиолдолд гэрээг цуцлах үүнээс үүдэн гарах бүх хохирлыг Гүйцэтгэгч хариуцах бөгөөд хэрэв ийм тохиолдол гаргасан бол гуравдагч этгээдийн буруутай үйл ажиллагаанаас болсон эсэхээс үл хамааран хохирол учруулсан тохиолдолд Гүйцэтгэгч хариуцлагыг үл маргах журмаар хүлээнэ.
7. Харилцаа 7.1. Талуудын гэрээний ерөнхий нөхцөлд холбогдох харилцаа нь зөвхөн бичгээр харилцсан тохиолдолд хүчинтэй байна. Бичгээр гаргасан мэдэгдэл нь нөгөө Тал хүлээн авснаар хүчинтэй болно.
8. Ажил туслан гүйцэтгүүлэх 8.1 Гүйцэтгэгч ажлын зайлшгүй шаардлагаар захиалагчийн зөвхөн бичгээр өгсөн зөвшөөрлөөр гэрээнд заасан зарим нэг ажил, үүргийг бусдад шилжүүлж болно. Ажлыг туслан гүйцэтгүүлэх нь Гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн ажлын үр дүн болон хариуцлагыг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.
- 8.2 Гүйцэтгэгчийн туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх нийт ажлын хэмжээ нь төсөвт өртгийн 25%-аас ихгүй байна.
9. Түншлэл 9.1. Энэхүү гэрээнд түншлэлээр оролцоогүй болно.
10. Бусад гүйцэтгэгчид 10.1 Гүйцэтгэгч нь бусад гүйцэтгэгч, засаг захиргааны байгууллага, нийтийн үйлчилгээний газар болон Захиалагчтай гэрээний тусгай нөхцөлийн дагуу бусад гүйцэтгэгчдийн хуваарьт заасан хугацаанд ажлын талбайг хамтран ашиглаж ажиллах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь тэдгээр этгээдийг уг хуваарьт заасны дагуу ажлын хэрэгсэл, үйлчилгээгээр хангана. Захиалагч нь бусад гүйцэтгэгчдийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд энэ тухайгаа Гүйцэтгэгчид мэдэгдэнэ.
11. Ажиллах хүчин 11.1 Гүйцэтгэгч гэрээний хавсралт 6-д дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчнийг, эсхүл Захиалагчийн зөвшөөрсөн бусад ажиллах хүчнийг ажиллуулна. Голлох мэргэжилтнийг өөрчлөх тухай Гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтийг зөвхөн санал болгож буй орлох мэргэжилтний чадвар нь дээрх хуваарьт заасан шаардлагын түвшинд, эсхүл түүнээс өндөр түвшинд байх нөхцөлд Захиалагч зөвшөөрч батална. Гүйцэтгэгч нь санал болгосон голлох мэргэжилтнийг зөвхөн энэхүү гэрээт ажилд ажиллуулах бөгөөд тогтвор суурьшилтай ажиллахад анхаарлаа хандуулна. Шаардлагатай тохиолдолд тухайн ажилтантай байгуулсан гэрээг /хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр



ажиллах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ г.м/ зайлшгүй хавсаргасан байна.

- 11.2 Хэрэв Захиалагч Гүйцэтгэгчийн аль нэг ажилтныг цаашид ажиллуулахгүй талаар үндэслэл бүхий саналыг Гүйцэтгэгчид тавьсан бол Гүйцэтгэгч тухайн ажилтныг 7 хоногийн дотор ажлаас чөлөөлж, түүнийг цаашид гэрээний дагуу гүйцэтгэх ажилд оролцуулахгүй.
- 12 Захиалагч, Гүйцэтгэгчийн хүлээх эрсдэл**
- 12.1 Захиалагчийн хүлээх эрсдэл, Гүйцэтгэгчийн хүлээх эрсдэл гэж энэхүү гэрээнд тодорхойлогдсон эрсдэлийг тус тус хүлээнэ. Эдгээр эрсдэлийг арилгах талаар талууд өөр өөрийн хүлээсэн үүргийн хүрээнд зохих арга хэмжээг авах үүрэгтэй.
- 13 Захиалагчийн хүлээх эрсдэл**
- 13.1 Ажил эхлэх өдрөөс зөрчил, доголдол арилгасан тухай мэдэгдэл гарах өдөр хүртэл хугацаанд Захиалагч дор дурдсан эрсдэлийг хүлээнэ:
- (а) Захиалагчийн гэм буруугаас болж ажил саатах эрсдэл
- 14 Гүйцэтгэгчийн хүлээх эрсдэл**
- 14.1 Ажил эхлэх өдрөөс зөрчил, доголдол арилгасан тухай мэдэгдэл гаргасан өдөр хүртэлх хугацаанд болон ажил бүрэн дуусах хүртэл хүн бэртэх, нас барах, түүнчлэн эд хөрөнгө (ажил, байгууламж, материалыг оролцуулах бөгөөд эдгээрээр хязгаарлахгүй) алдагдах, эвдэрч гэмтэхээс үүдэн гарах Захиалагч, Гүйцэтгэгч болон 3-дагч этгээдэд учрах эрсдэлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна. Зохих хуулийн дагуу Гүйцэтгэгчийн хүлээх бүх хариуцлагыг хүлээнэ.
- 14.2 Ажлыг хүлээлгэж өгөхөөс өмнө гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас ажил, байгууламж, материал болон тоног төхөөрөмж гэмтэх, саатах эрсдэлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.
- 14.3 Гэрээнд гарын үсэг зурснаар Гүйцэтгэгч нь гэрээний ажилд саад болж болох бүхий л эрсдэлийг тооцсон болон түүний зардлын талаар үүсэх бүх үүргийг өөрөө хариуцахаа үүгээр хүлээн зөвшөөрч байна.
- 15 Даатгал**
- 15.1 Гүйцэтгэгчийн хүлээх эрсдэлд хамаарах дор дурдсан тохиолдлын даатгалыг Гүйцэтгэгч нь өөрийн зардлаар ажил эхлэх өдрөөс чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл хугацаанд ГТН-ийн 15 дугаар зүйлд заасан дүнгээр заавал даатгуулсан байна. Үүнд:
- (а) ажил, байгууламж болон материал алдагдах, эвдэрч гэмтэх;
- (б) тоног төхөөрөмж алдагдах, эвдэрч гэмтэх;
- (в) гэрээний хэрэгжилттэй холбогдож эд хөрөнгө (ажил, байгууламж, материал, тоног төхөөрөмжөөс бусад) алдагдах, эвдэрч гэмтэх; /Гүйцэтгэгч, захиалагч, 3-дагч этгээдийн/
- (г) Хүн бэртэх, эсхүл нас барах. /Гүйцэтгэгч, захиалагч, 3-дагч этгээдийн/
- (д) Гүйцэтгэгч, түүний ажилтан, Бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгчийн хариуцлага алдагдах.

- (е) Гэрээний дагуу гүйцэтгээгүй үүрэг болон гүйцэтгэсэн ажлын доголдол, зөрчил, дутагдал
- 15.2 Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээг ажил эхлэх өдрөөс өмнө Захиалагчид хүргүүлнэ. Даатгалыг дээр заасан тохиолдлоос үүдэн гарсан хохирлыг арилгахад зориулна.
- 16 Ажлын талбайн судалгааны тайлан**
- 16.1 Гүйцэтгэгч ажлын талбайн судалгааны тайлан болон бусад нэмэлт мэдээллийг ашигласан байна.
- 16.2 Гүйцэтгэгч нь гэрээний ашиглалтын талбай, ойр орчмын талбай, талбайн газарзүйн болон цаг агаарын онцлог шаардлагатай аливаа үйл ажиллагааны талаар бүх мэдээлэл, эрсдэл болон ажил олгогч, үндсэн гэрээ байгуулагч, ажил олгогч, бусад Гүйцэтгэгчдийн талаар шаардлагатай мэдээлэлтэй байх ёстой.
- 16.3 Дээр заасан мэдээллийн талаар Захиалагч, Гүйцэтгэгч нар аливаа мэдээллээр хангах бөгөөд үнэн зөв оновчтой эсэхийг Гүйцэтгэгч шалгана. Энэхүү мэдээллийн хувьд Захиалагч, Гүйцэтгэгч нар аливаа нэг үүрэг, Гүйцэтгэгчийн өмнө хүлээхгүй.
- 16.4 Гүйцэтгэгч ашиглалтын талбайн талаар хангалттай мэдээлэл байхгүй болон түүнээс үүсэх аливаа шалтгаанаар ажлын хугацаа сунгагдсан тохиолдолд нэмэлт хөлс авахгүй.
- 16.5 Гүйцэтгэгч ашиглалтын талбайн эрүүл мэнд, техникийн аюулгүй ажиллагааны бүхий л нөхцөлийг хангаж ажиллах ба үүнтэй холбоотой зардлыг өөрөө хариуцна.
- 17 Гэрээний тусгай нөхцөлийн тухай асуулга**
- 17.1 Гэрээний тусгай нөхцөлийн талаар гарсан асуудлыг Захиалагч, Гүйцэтгэгчээс тодруулж, тайлбар гаргуулна.
- 18 Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх**
- 18.1 **Гүйцэтгэгч** ажлыг техникийн шаардлага болон батлагдсан зургийн дагуу Захиалагчийн хяналт дор хийж гүйцэтгэнэ.
- 18.2 Ажил /ажлын объём/ -ыг батлагдсан ажлын зураг, төсөвт тусгагдсаны дагуу бүрэн чанартай гүйцэтгэнэ.
- 18.3 Батлагдсан ажлын зураг, төсөвт тусгагдсаны дагуу техникийн тодорхойлолт, шаардлагад дүйцэж нийцсэн буюу чанараар илүү материал, тоног төхөөрөмжийг ашиглан ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн Улсын комисст хүлээлгэн өгнө.
- 19 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх**
- 19.1 **Гүйцэтгэгч** ажлыг товлосон өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын графикийг Захиалагчийн баталсан, тодотгосон ажлын графикийн дагуу хийж гүйцэтгэн, ГТН 1.1-д заасан ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
- 20 Захиалагч баталгаажуулах / Инженер /**
- 20.1 Гүйцэтгэгч нь гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг хариуцна.
- 20.2 Инженер нь туслах ажлын зураг төсөл түүнтэй Гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
- 20.3 Шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэгч туслах ажлын зураг төсөлд холбогдох байгууллагын зөвшөөрөл авна.
- 20.4 Гүйцэтгэгчийн бэлтгэсэн түр болон үндсэн ажилд ашиглах бүх зураг төслийг ажил эхлэхээс өмнө Инженер батална.

- 21 Аюулгүй байдал
- 21.1 Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг бүрэн хариуцна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартуудыг мөрдөж ажиллана.
- 21.2 Барьж байгаа Тавантолгой өртөөний 35/10 кВ иж бүрэн хуваарилах байгууламж, дэд станц болон шугам барих ажлаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч ёсчлон биелүүлсэн байна.
- 21.3 Гүйцэтгэгч нь ажлын талбай дээр хяналт тавьж буй өөрийн ажилтнууд болон Захиалагч болон Инженерийн ажиллах нөхцөл болон Хөдөлмөрийн болон эрүүл ахуйн аюулгүй байдлыг бүрэн хангана.
- 21.4 Гүйцэтгэгч гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэхдээ хуульд заасан бүхий л шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй. Үүнд материал, тоног төхөөрөмж, үйлчилгээ, үйлдвэр зэрэгт гаргасан төрийн бүхий л стандарт, журам, хууль тогтоомжийг дагаж ажиллах үүрэгтэй.
- 21.5 Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэхдээ “Ажлын талбай дээр” бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй, эрчим хүчний чиглэлээр их, дээд сургууль төгссөн инженерээр ажлыг удирдуулж, тогтмол ажлын талбай дээр ажиллуулах үүрэгтэй.
- 21.6 Гүйцэтгэгч нь “Ажлын талбай” дээр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н чиглэл хариуцсан бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй, эрчим хүчний чиглэлээр их, дээд сургууль төгссөн /ХАБЭА-ийн чиглэлээр зохих сургалтад хамрагдсан/ инженер томилон тогтмол талбай дээр ажиллуулах үүрэгтэй.
- 21.7 Гүйцэтгэгчийн ажил удирдагч нь ХАБЭА чиглэл хариуцсан ИТА нар өдөр тутмын болон бусад холбогдох аюулгүй ажиллагааны зааварчилгааг бригадын бүрэлдэхүүнд тогтмол өгч байх үүрэгтэй.
- 21.8 Бригадын бүрэлдэхүүн “ажлын талбай” дээр байнга ажлын нормын хувцсыг бүрэн хэрэглэж, каскан малгай өмсөж байхыг шаардаж, хэрэв талбай дээр нормын бүрэн хувцас хэрэглэлгүй хүнийг ажиллуулахгүй байх үүрэгтэй.
- 21.9 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх үедээ техникийн шаардлага хангасан бүрэн бүтэн тээврийн хэрэгсэл, хүнд механизм болон ажлын багаж, хамгаалал хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглах үүрэгтэй.

- 22 Олдвор** 22.1 Ажлын талбайд санамсаргүй олж илрүүлсэн түүх дурсгалын болон бусад үнэт эд зүйлс нь Монгол улсын өмч болно<sup>1</sup>. Гүйцэтгэгч нь олдворыг Захиалагчид нэн даруй мэдэгдэх бөгөөд Захиалагчид Соёлын өвийн тухай хуулийн дагуу холбогдох байгууллагад мэдэгдэж, энэ талаар түүний зааварчилгааг биелүүлнэ.
- 23 Ажлын талбайг ашиглуулах** 23.1 Захиалагч зам, барилга барих эдэлбэр газрын болон ажлын талбайд орсон бүх төрлийн барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, авто болон төмөр замыг буулгах, зөөх, шилжүүлэх, хөдөлгөөнийг зогсоох зөвшөөрөл олгоно.
- 23.2 Уг барилгын цахилгаан, дулаан, цэвэр, бохир усан хангамж, уур, телефон, радио холбооны инженерийн шугам сүлжээнд холбох эх үүсвэрийг тодорхойлсон техникийн нөхцөл, зураг төсөл, барилгын ажил эхлэх зөвшөөрөл, улаан шугам тавьсан акт, бусад холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгч ажлын талбайн бүх хэсгийг Гүйцэтгэгчид ашиглуулна.
- 23.3 Гүйцэтгэгч нь "Ажлын талбай" дээр гадны байгууллагын эзэмшлийн инженерийн шугам сүлжээ, байгууламж, /эрчим хүч, дулаан хангамжийн шугам сүлжээ, шилэн кабель гэх мэт/ оршин байгаа нөхцөлд уг шугам сүлжээ, байгууламжтай холбоотой ажил гүйцэтгэх тохиолдолд тухайн инженерийн шугам сүлжээ, байгууламж эзэмшигчээс ажил эхлэх, ажил гүйцэтгэх зөвшөөрлийг зайлшгүй авсны дараа тухайн байгууллагын хяналт доор ажлыг эхлүүлнэ.
- 23.4 Гүйцэтгэгч нь өөрийн тоног төхөөрөмж, эд материалыг хариуцна. Монголд болон ашиглалтын талбайд авчирсан тэдгээрийн тоног төхөөрөмж нь зөвхөн гэрээний үүргийг гүйцэтгэхэд ашиглагдана.
- 24 Ажлын талбайд нэвтрэн орох** 24.1 Гүйцэтгэгч нь Инженер болон түүний эрх олгосон аливаа этгээдийг ажлын талбайд болон гэрээний ажилтай холбоотой ажил явагдаж буй, эсхүл хийхээр төлөвлөж буй аливаа газарт нэвтрүүлэх үүрэгтэй. Энэ эрх нь Захиалагчид мөн адил үйлчилнэ.
- 24.2 Гүйцэтгэгч нь Захиалагчийн эрх олгосон этгээдийг ажлын талбайд болон гэрээний ажилтай холбоотой ажил явагдаж буй, эсхүл хийхээр төлөвлөж буй аливаа газарт нэвтрүүлэх, санхүү бүртгэлийн тайлан тооцоотой холбоотой шаардлагатай мэдээллийг өгөх үүрэгтэй.
- 25 Зааварчилгаа** 25.1 Инженерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн байх бөгөөд Гүйцэтгэгч түүнийг заавал биелүүлэх үүрэгтэй.
- 26 Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх** 26.1 Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх ба Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 27 Маргаан шийдвэрлэх** 27.1 Хэрэв маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд талууд уг маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 28 Давагдашгүй хүчин зүйл** 28.1 Дайн, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг зэрэг нөхцөл байдал үүссэнийг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэж үзнэ.

<sup>1</sup>Инженер нь олж илрүүлсэн түүх дурсгалын болон бусад үнэт эд зүйлсийг зохих журмын дагуу холбогдох байгууллагад шилжүүлнэ.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

28.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд Гүйцэтгэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар Захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Гүйцэтгэгч Гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан Гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

## Б. ХУГАЦААНЫ ХЯНАЛТ

### 29 Ажлын график

29.1 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын үе шатны ажлын графикийг боловсруулж, ГТН-ийн 29 дугаар зүйлд заасан хугацаанд Захиалагчид хүргүүлж батлуулна.

29.2 Ажлын графикийг тодотгохдоо үйл ажиллагаа бүрийн явц, үр дүн, тэдгээрийн үлдэж буй ажлыг гүйцэтгэх хугацаанд үзүүлэх нөлөө болон үйл ажиллагааны дараалалд оруулсан аливаа өөрчлөлтийг тусгана.

29.3 Гүйцэтгэгч нь тодотгосон ажлын графикийг ГТН 29-д заасан хугацаанд Захиалагчаар батлуулахаар хүргүүлнэ. Хэрэв Гүйцэтгэгч тодотгосон ажлын графикийг энэ хугацаанд хүргүүлээгүй бол Захиалагч ГТН 29-д заасан дүнг дараагийн гүйцэтгэлийн төлбөрөөс хасаж Гүйцэтгэгч ажлын график ирүүлсний дараа хийгдэх төлбөр хүртэл саатуулна.

29.4 Ажлын графикийг Захиалагч батлах нь Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын графикийг хянан засварлаад Захиалагч хуанлийн 7 хоногийн дотор хүргүүлнэ. Хянан засварласан ажлын графикт өөрчлөлт болон нөхөн төлбөр хийх нөхцөлийн нөлөөг тусгаж Санхүүжүүлэгч, Захиалагчийн саналыг авна.

### 30 Ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгах

30.1 Хэрэв зургийн өөрчлөлтийн улмаас Гүйцэтгэгч нэмэлт зардал гаргалгүйгээр ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр түүнийг дуусгах боломжгүй бол Захиалагч нь Санхүүжүүлэгч, Зөвлөх-Хяналтын багтай зөвшилцөн ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгана.

30.2 Гүйцэтгэгч зургийн өөрчлөлтийн үр дагаврын талаар зохих шийдвэр гаргахыг хүсэж, үүнийг нотлох холбогдох мэдээллийг ирүүлснээс хойш 3 хоногийн дотор Захиалагч нь ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгах эсэх, сунгах бол ямар хугацаагаар сунгах тухай шийдвэрийг Санхүүжүүлэгчтэй зөвшилцөн гаргана. Хэрэв Гүйцэтгэгч хугацаа хоцорсныг урьдчилан анхааруулаагүй, эсхүл хугацаа хоцролтыг арилгах асуудлаар хамтран ажиллаж чадаагүй бол үүнийг ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг шинээр тогтооход харгалзан үзэхгүй.

- 31 Инженерийн шийдвэрээр хугацааг хойшлуулах**
- 31.1 Чиглэл хариуцсан инженер ажлын аль нэг үйл ажиллагааны эхлэл, эсхүл явцыг хойшлуулах зааварчилгааг Гүйцэтгэгчид өгөх эрхтэй. Энэ нь ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгахаар тохиолдолд энэ тухай заавал Захиалагчтай зөвшилцсөн байна.
- 31.2 Гүйцэтгэгч нь ямар ч тохиолдолд /зөвхөн Захиалагч, Санхүүжүүлэгчийн буруутай үйл ажиллагаа хамаарахгүй/ бусад, бүх тохиолдлыг энд ойлгоно/ гэрээний үүргээ ГТН 1.1-д заасан хугацаанд биелүүлж чадаагүй, хугацаа хэтрүүлсэн бол ГТН 49-д заасан хувь хэмжээгээр хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги тооцож төлүүлнэ. Энэхүү төлбөрийг гүйцэтгэлийн баталгаанаас хасаж тооцож болох ба түүнчлэн захиалагч, санхүүжүүлэгчид төлөх ёстой өр хэлбэртэйгээр Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй. Хугацаа хэтэрснээс нөхөн төлж буй төлбөр нь Гүйцэтгэгчийг үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 32 Төлөөлөгч болон Ажлын уулзалт**
- 32.1 Гүйцэтгэгч ГТН 1.1-д өөрийн бүхий л үйл ажиллагааг төлөөлөх эрхтэй хүнийг сонгож нэрийг тэмдэглэнэ. Хэрэв ГТН-д өөрөөр заагаагүй бол гэрээ байгуулснаас 7 хоногийн дотор гэрээ байгуулагчид тэр хүний нэрийг илгээнэ. Тухайн этгээд нь эргүүлэн татагдсан эсхүл Гүйцэтгэгчийг төлөөлж чадахгүй гэж Захиалагч үзвэл энэ ажилд тохирох хүнийг дахин Гүйцэтгэгч төлөөлөгчөөр томилох үүрэгтэй.
- 32.2 Төлөөлөгч нь Захиалагч зохион байгуулж буй албан ёсны уулзалтад оролцож Гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс үүрэг хүлээж биелүүлэх үүрэгтэй. Гүйцэтгэгч захиалагчийн зөвшөөрөлгүйгээр төлөөлөгчөө солих татах эрхгүй.
- 32.3 Захиалагч нь Гүйцэтгэгчтэй төлөөлөгчөөр дамжуулан харилцана. Төлөөлөгч Гүйцэтгэгчийн бүхий л эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 32.4 Захиалагч, Гүйцэтгэгчийн аль аль нь ажлын уулзалтад оролцохыг нөгөө талаасаа шаардах эрхтэй. Ажлын уулзалтад үлдэж буй ажлын төлөвлөгөөг хянан үзэж, урьдчилан анхааруулах журмын дагуу гарсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 32.5 Инженер ажлын уулзалтын тэмдэглэлийг үйлдэж, уг тэмдэглэлийн хувийг уулзалтад оролцсон хүмүүст болон Захиалагчид хүргүүлнэ. Хийгдэх арга хэмжээнд талуудын хүлээх үүрэг хариуцлагыг Инженер уг ажлын уулзалтад дээр, эсхүл түүний дараа шийдвэрлэж, энэ тухай ажлын уулзалтад оролцсон бүх этгээдэд бичгээр мэдэгдэнэ.
- 33 Урьдчилан анхааруулах журам**
- 33.1 Гүйцэтгэгч ажлын чанарт сөргөөр нөлөөлөх, гэрээний үнийг өсгөх, эсхүл хугацаа хоцроож болзошгүй нөхцөл байдлын талаар Инженерт аль болох урьдаас урьдчилан анхааруулах үүрэгтэй. Инженер гарч болзошгүй нөхцөл байдал нь гэрээний үнэ болон ажил дуусгахаар төлөвлөсөн хугацаанд хэрхэн нөлөөлж болох талаарх мэдээллийг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй. Гүйцэтгэгч уг мэдээллийг аль болох богино хугацаанд ирүүлнэ.
- 33.2 Гүйцэтгэгч эдгээр нөхцөл байдлын үр дагаврыг арилгах, эсхүл багасгах санал гаргаж инженерийн гаргасан зааварчилгааг хэрэгжүүлэхдээ түүнтэй хамтран ажиллана.
- 33.3 Гүйцэтгэгч нь дараах тохиолдолд Захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй Үүнд:

- 33.3.1 ажил гүйцэтгүүлэхээр Захиалагчийн баталсан материал, ажил гүйцэтгэх талаар Захиалагчийн өгсөн зааварчилгаа нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байдал үүссэн;
- 33.3.2 ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, Гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон;
- 33.4 Гүйцэтгэгч эдгээр нөхцөл байдлын үр дагаврыг арилгах, эсхүл багасгах санал гаргаж Инженерийн гаргасан зааварчилгааг хэрэгжүүлэхдээ түүнтэй хамтран ажиллана.
- 33.5 Инженер нь үнэ, төлөвлөсөн хугацаанд зайлшгүй өөрчлөлт орох шаардлагатай гэж үзвэл Захиалагчид урьдчилан мэдэгдэж, зааварчилгаа авна.

## В. ЧАНАРЫН ХЯНАЛТ

### 34 Зөрчил, доголдол илрүүлэх

- 34.1 Инженер Гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Инженер зөрчил, доголдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, доголдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

### 35 Туршилт

- 35.1 Хэрэв Инженер аливаа ажил зөрчил, доголдолтой эсэхийг шалгах зорилгоор техникийн шаардлагад заагаагүй шалгалт туршилт явуулах зааварчилгааг Гүйцэтгэгчид өгч, түүгээр зөрчил, доголдол илэрсэн бол Гүйцэтгэгч шалгалт туршилт явуулсан зардлыг төлнө.

### 36 Зөрчил, доголдол арилгах

- 36.1 Инженер ГТН 36-д заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, доголдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 36.2 Зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг Инженерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж Гүйцэтгэгч нь өөрийн зардлаар арилгана.
- 36.3 Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийсэн ажил нь чанарын доголдолтой эсхүл гэрээний шаардлага, графикийн дагуу хийгдээгүй тохиолдолд мөн залруулах ёстой тодорхой хугацаанд хийж чадаагүй бол Захиалагч, Инженерийн бичгээр өгсөн мэдэгдлийн дагуу гүйцэтгэгчийн зардлаар уг асуудлыг шийдвэрлэнэ.
- 36.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд ашиглаж буй Гүйцэтгэгчийн материал, тоног төхөөрөмж нь техникийн тодорхойлолтод заасан чанар, стандартын шаардлагыг хангасан байх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол техникийн тодорхойлолтод заасан материал тоног төхөөрөмжөөр солих, үүнтэй холбоотой зардлыг өөрөө төлж үүний улмаас төлөвлөгөөт хугацаа хэтэрсэн тохиолдолд хариуцлагыг гүйцэтгэгч өөрөө бүрэн хариуцна

- 37 Зөрчил, доголдол арилгахгүй байх
- 37.1 Хэрэв Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг Инженерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол Инженер зөрчил, доголдол арилгахад шаардагдах зардлыг тооцож барьцаа хөрөнгөөр зөрчил доголдлыг арилгах тухай мэдэгдлийг Захиалагчид хүргүүлж Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс эсвэл барьцаа хөрөнгөөс гаргуулна.
- 37.2 Зөвлөх Хяналтын үүрэг гүйцэтгэж буй “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-аас гаргасан “Захиалагчийн хяналтын дүгнэлт”-нд тусгагдсан заалтыг нэг бүрчлэн хэрэгжүүлж, зөрчил доголдлыг тухай бүрд нь арилгах.

#### Г. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 38 Үе шатны ажлын хуваарь
- 38.1 ГТН 29-д заасан хугацаанд Инженерийн шаардсаны дагуу Гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 3 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын графикт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна. Гүйцэтгэгч нь түншлэл болон оролцож байгаа тохиолдолд, үе шатны ажлын хуваарийг түншлэлийн нийт гүйцэтгэх ажлаар тооцон гаргана. Үе шатны ажлын тайлан гаргах хуваарийг Хавсралт 7-д заасан болно.
- 39 Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх
- 39.1 Захиалагчийн шийдвэрээр ажлын аргачлал, эсхүл ажлын графикт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор Гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийж болно. Энэ тохиолдолд Захиалагчид заавал бичгээр хүргүүлж зөвшилцсөн байна. Гэхдээ үндсэн хугацаа өөрчлөгдөхгүй. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 40 Өөрчлөлт
- 40.1 Бүх өөрчлөлтийг Гүйцэтгэгчийн боловсруулсан тодотгосон ажлын график болон үе шатны ажлын хуваарьт тусгасан байна.
- 41 Өөрчлөлтийн улмаас хийх төлбөр
- 41.1 Инженер шаардсан бол Гүйцэтгэгч өөрчлөлтөөр хийгдэх ажлын үнийн саналыг түүнд гаргаж өгнө. Инженер шаардсанаас хойш 3 хоногийн дотор, эсхүл Инженерийн тогтоосон үүнээс урт хугацаанд үнийн саналыг ирүүлнэ. Инженер үнийн саналыг хянаж, Захиалагч, Зураг зохиогчтой зөвшилцсөний дараа өөрчлөлт хийх зөвшөөрөл өгнө.
- 41.2 Хэрэв Инженер, Захиалагч нь Гүйцэтгэгчийн гаргасан үнийн саналыг үндэслэлгүй гэж үзвэл Инженер нь Гүйцэтгэгчийн зардалд уг өөрчлөлт хэрхэн нөлөөлөх талаарх өөрийн тооцоонд үндэслэн, гэрээний үнийг өөрчлөх тухай саналыг Захиалагчид гарган шийдвэрлүүлнэ.
- 41.3 Хэрэв Инженер ажилд яаралтай өөрчлөлт оруулах, ажлыг хугацаа хоцроолгүй гүйцэтгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Гүйцэтгэгч гэрээний дүнд багтаан ажил гүйцэтгэнэ.
- 41.4 Гүйцэтгэгч урьдчилан анхааруулснаар гаргахгүй байх боломжтой байсан зардалд нэмэлт төлбөр нэхэмжлэх эрхгүй.



- 42 Бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоо
- 42.1 Гүйцэтгэгч ажлын графикийг эсхүл үе шатны ажлын хуваарийг тодотгосон тохиолдолд бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоог Инженерт гаргаж өгнө. Бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоог гэрээнд заасан валютын төрөл, ханшаар хийнэ.
- 43 Төлбөрийн мэдэгдэл
- 43.1 Инженер Гүйцэтгэгчийн ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг шалгаж, түүнд төлөх төлбөрийн дүнг тодорхойлж, холбогдох эд материал болон үйлчилгээний нэхэмжлэл зэргээр баримтжуулж батална.  
Гүйцэтгэгч нь хийгдсэн ажлын гүйцэтгэлийн тайланг сар бүр Инженерт гаргаж өгөх бөгөөд түүнд нэхэмжилсэн дүн нь нийт гарсан зардлаас өмнө нэхэмжилсэн дүнг хассан хэмжээтэй байна.
- 43.2 Гүйцэтгэсэн ажилд төлөх төлбөрийн дүнг тооцохдоо үе шатны ажлын хуваарьт заасан бүрэн хийж гүйцэтгэсэн үе шатны ажлын үнэд үндэслэнэ.
- 43.3 Өмнөх төлбөрийн мэдэгдэлд хамрагдсан зардлыг дахин нэхэмжилсэн бол Инженер түүнийг төлбөр хийх дүнгээс хасна.
- 44 Төлбөр
- 44.1 Гэрээнд дагуу ГТН 43-д заасан хугацаанд холбогдох ажлын тайлан, эд материалыг нэхэмжлэлээр баримтжуулж, Инженер баталгаажуулна. Үүнд Инженерийн баталгаажуулах хугацаа орно.
- 44.2 Төлбөрийг шилжүүлэхээр Санхүүжүүлэгчид мэдэгдлийг хүргүүлэхдээ холбогдох урьдчилгаа төлбөр, алданги, торгууль болон барьцаа хөрөнгийг хасаж тооцно.
- 44.3 Хэрэв сүүлд ирүүлсэн мэдэгдлээр, эсхүл шүүхийн шийдвэрийн улмаас өмнөх мэдэгдэлд заагдсан дүн нэмэгдсэн бол хугацаа хоцорсон төлбөрт ногдох торгуулийг энэ зүйлд заасны дагуу Гүйцэтгэгч төлнө. Торгуулийг нэмэгдсэн дүнг төлөх ёстой байсан өдрөөс эхэлж тооцно.
- 44.4 Нэгж болон нийт үнийг тусгаагүй ажлын нэр төрөлд Захиалагч төлбөр хийхгүй бөгөөд тэдгээрийг гэрээнд заасан бусад нэгж болон нийт үнэд орсон гэж үзнэ.
- 44.5 Гэрээний үнэ гэрээний хүчинтэй хугацааны дотор тогтмол байна.
- 44.6 ГТН 45-д өөрөөр тохиролцоогүй бол бараа материал, хүн хүчний үнийн өөрчлөлтөөс хамаарч гүйцэтгэх ажлын үнэ ханш өөрчлөгдөхгүй тогтмол байна.
- 44.7 Гэрээнд олгохоор тохиоролцсон мөнгөн дүнгээс гүйцэтгэл бага байх тохиолдолд гүйцэтгэлээр нь тооцон төлбөрийг төлнө.
- 44.8 ГТН 45-д өөрөөр тохиролцоогүй бол гүйцэтгэх ажлын үнэ, ханш, дуусгах цаг зэрэгт шинээр батлагдсан хууль, төрийн аливаа шийдвэрүүдэд нэмэлт өөрчлөлт орсон нь гэрээний үнэд өөрчлөлт орох үндэслэл болохгүй.

- 44.9 Гүйцэтгэгч нь хамгийн эхний санхүүжилтээс Захиалагчид батлагдсан хяналтын төсвийн нэмэгдэл зардлын 30%-тай тэнцэх мөнгийг "УБТЗ" ХНН-ын Голомт банкны 3405125425 тоот дансанд шилжүүлнэ.
- 44.10 Гэрээт ажлын төлбөрийг заасан хугацааны дотор шилжүүлээгүйтэй холбоотой хариуцлагыг Санхүүжүүлэгч хариуцах бөгөөд үүнтэй холбоотой гарах хохирол алданги хариуцлагын асуудлыг Гүйцэтгэгч Санхүүжүүлэгчтэй байгуулах санхүүжилтийн гэрээгээрээ зохицуулна.
- 44.11 Гүйцэтгэгч, Санхүүжүүлэгч нар нь төлбөр төлөхтэй холбоотой ямар нэг маргаантай асуудлаас Захиалагчийг ангид байлгана.
- 44.12 Санхүүжилтээс шалтгаалан ажлын гүйцэтгэл Хавсралт №4-д заасан графикт хугацаанаас хоцорвол Захиалагч хариуцлага хүлээхгүй.
- 45 Татвар**
- 45.1 Гүйцэтгэгч нь Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой.
- 45.2 Энэхүү гэрээний 44.09-д заасан мөнгө нь зохих ёсоор татвар хураамж суутган тооцогдсон эцсийн дүн гэж үзнэ.
- 46 Валют**
- 46.1 Бүх төлбөрийг ГТН-ийн 47-д заасан хэлбэрээр хийнэ.
- 47 Алданги, торгууль**
- 47.1 Санхүүжүүлэгч, Захиалагч нь Гүйцэтгэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хоног тутам ГТН 49-д заасан хэмжээгээр алданги ногдуулна. Үүнд: Гэрээний ерөнхий нөхцөлийн 15, 18, 19, 21, 25, 29, 33, 35, 36, 37, 44.9, 50, гэрээний хавсралт 1, 2, 5, 6, 8, 9 тус тус заасан нөхцөлүүдийг биелүүлээгүй тохиолдлыг авч үзнэ.
- 47.2 Гүйцэтгэгч нь ажил дуусахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд ГТН 49-д заасан хувь хэмжээгээр алданги төлнө.
- 47.3 Захиалагч нь алдангийг Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс үл маргах журмаар суутган авна. Алданги төлсөн нь Гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
- 47.4 ГТН-ийн 6-д заасан үүргийг гүйцэтгэгч биелүүлээгүй тохиолдолд захиалагч ГТН 49-д заасан хэмжээний торгуулийг ногдуулна.
- 47.5 Гүйцэтгэгч гэрээт ажлыг гэрээний хавсралт 5-д заасан үе шатны ажлыг заасан хугацаанд Захиалагчид хүлээлгэн өгөөгүй бол хугацаа хэтэрсэн тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги тооцно.
- 47.6 Хавсралт №8-д заасан бичиг баримтыг дутуу өгсөн тохиолдолд 10.0 сая төгрөгийн торгууль тооцно.
- 48 Урьдчилгаа төлбөр**
- 48.1 Гэрээт ажлын төлбөрийг гүйцэтгэлээр санхүүжүүлэх буюу эсвэл банкны баталгааг үндэслэн 30 хүртэл хувийн урьдчилгаа төлбөр олгож болно.
- 48.2 Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг зөвхөн гэрээг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, байгууламж, материал болон ажил эхлүүлэхтэй холбогдсон зардалд зарцуулна. Гүйцэтгэгч

урьдчилгаа төлбөрийг энэ зорилгод ашигласныг нотлохын тулд нэхэмжлэх болон бусад баримтын хувийг Захиалагч болон Санхүүжүүлэгчид ирүүлнэ. Урьдчилгаа төлбөрийг энэ зориулалтаас өөрөөр ашиглахыг хатуу хориглоно.

- 48.3 Урьдчилгаа төлбөр нь хийгдсэн үе шатны ажлын дагуу Гүйцэтгэгчид төлөх төлбөрийн хэмжээнээс холбогдох дүнг суутгах замаар эргэж төлөгдөнө. Хийгдсэн ажлын үнэ, өөрчлөлт, үнийн тохируулга, нөхөн төлбөр, урамшуулал болон алдангийн дүнг тооцохдоо урьдчилгаа төлбөр, эсхүл түүний эргэж төлөгдсөн байдлыг харгалзахгүй.
- 49 Чанарын Баталгаа** 49.1 Чанарын баталгаат хугацаанд гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувийг суутган тооцож, баталгаат 4 жилийн хугацаа дуусгавар болсны дараа гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ. Чанарын баталгаат хугацаа гэж ажлыг бүхэлд нь букуу хэсэгчлэн Улсын комисс хүлээн авч Гүйцэтгэгч Захиалагч гэрээ дүгнэсэн акт үйлдэж албан ёсоор баталгаажсан тухайн өдрөөс тооцно.
- 50 Засварын зардал** 50.1 Ажил эхэлсэн өдрөөс чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас, эсхүл дутуу орхисноос үүдэн гарсан гэрээний ажилтай холбоотой материал болон ажилд үүссэн алдагдал, дутагдал, доголдол, эвдрэл, гэмтлийг Гүйцэтгэгч өөрийн зардлаар засварлана.
- 51 Нөхөн төлбөр** 51.1 Доорх үйл ажиллагаанаас үүсэх **Гүйцэтгэгчийн** буруутай үйл ажиллагаанаас хамааран гарсан аливаа зардал, төлбөр, алдагдал, хураамж зэргийг гүйцэтгэгч хариуцан арилгана. Үүнд: Гүйцэтгэгчийн гэрээт ажилтнууд болон захиалагч, 3-дагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол, Захиалагч болон бусад 3-дагч этгээдийн эд хөрөнгөнд учирсан аливаа хохирол, Гэрээний дагуу гүйцэтгээгүй үүрэг болон гүйцэтгэсэн ажлын доголдол, зөрчил, дутагдал. **Гүйцэтгэгчийн** гэм буруутай үйл ажиллагааны улмаас үүдэн гарсан бусад хохирол зардал,
- 51.2 Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад аливаа нэг хохирол болон алдагдал хүлээсэн тохиолдолд түүний буруутай эсэхээс үл хамааран хохирлыг өөрөө барагдуулна. Үүнтэй холбоотой аливаа нэг төлбөр, маргаанаас Захиалагчийг ангид байлгахаа үүрэг баталж байгаа болно.

#### Д. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

- 52 Ажил дуусгах** 52.1 Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг Инженерт тавих бөгөөд Инженер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг хүлээн авна. Гүйцэтгэгч гадна болон ажлын талбайн тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, явган хүний зам талбай, ус зайлуулах хоолой г.м, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 53 Хүлээж авах** 53.1 Инженер нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргахаас өмнө холбогдох мэргэжлийн байгууллагаар тухайн угсралтын ажлын техник ашиглалтын түвшинг тогтоолгосон байна.

- 53.2 Гүйцэтгэгч нь Техникийн болон Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврыг өөрийн зардлаар гүйцэтгэж, биелэлтийг хуанлийн 14 хоногийн дотор Техникийн болон Улсын комисст хүргүүлнэ.
- 53.3 Улсын комиссоос өгсөн үүрэг даалгавар бүрэн биелснээс хойш ажлын 5 хоногийн дотор Захиалагч ажлын талбай болон ажлын үр дүнг хүлээж авна.
- 53.4 Гүйцэтгэгч нь техникийн комисс болон Улсын комисст хүлээлгэн өгөх үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг шууд хариуцна.
- 53.5 Гүйцэтгэгч нь Техникийн болон Улсын комисс ажиллах шаардлагатай холбогдох бүх баримт бичгийн Эрчим Хүчний яамны Сайдын 2019 оны 05.01-ний өдрийн 125 -р тушаалд заасны дагуу бүрдүүлж "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨҮГ-аар хянуулсны дараа гэрээт ажлын хугацаа дуусах өдөр Захиалагч тал "УБТЗ" ХНН-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжид хүлээлгэн өгнө.
- 53.6 Санхүүжүүлэгч болон Захиалагч тал нь техникийн комисс болон Улсын комисст хүлээлгэн өгөх үйл ажиллагааны зохион байгуулалтыг хариуцна.
- 54 Эцсийн тооцоо**
- 54.1 Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө Захиалагчид хүргүүлнэ. Захиалагч зөрчил, доголдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв Гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор Гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаар тайлбарыг 28 хоногийн дотор гаргаж Гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол Захиалагч Гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 55 Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага**
- 55.1 Гүйцэтгэгч нь Техникийн болон Улсын комисс ажиллах үед шаардлагатай бүх бичиг баримтыг бүрдүүлэх бөгөөд Захиалагчийн шаардсанаар ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг ГТН-ийн 55 дугаар зүйлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө. Захиалагчид хүлээлгэн өгөх баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 9-д заасан болно.
- 55.2 Хэрэв Гүйцэтгэгч 55.1-д заасан материалыг ГТН-ийн 55 дугаар зүйлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг Инженер батлаагүй бол Гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс Инженер ГТН-ийн 55 дугаар зүйлд заасан үнийн дүнг суутган төлбөрийн мэдэгдэл бичнэ.
- 56 Гэрээг цуцлах**
- 56.1 Захиалагч нь Гүйцэтгэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй. Захиалагч бичгээр мэдэгдсэн албан бичигт заасан хугацаанд эсхүл мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дараа Гэрээ цуцлагдсанд тооцно.
- 56.2 Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзнэ:

- (а) Ажлын графикт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг Инженер батлаагүй байхад Гүйцэтгэгч ажлыг 3 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
- (б) Гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй болсон. эсхүл дампуурсан, эсхүл албадан журмын дагуу татан буугдаж байгаа,
- (в) Гэрээгээр хүлээсэн ажил үүргийг гүйцэтгэхэд нэн шаардлагатай эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн хугацаа дууссан цаашид сунгагдах боломжгүй болсон, хүчингүй болгосон,
- (г) Тодорхой зөрчил, доголдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг Инженер Гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд Гүйцэтгэгч нь уг зөрчил, доголдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) Гүйцэтгэгч Захиалагчийн шаардсан баталгааг хангаагүй;
- (е) Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг ГТН-ийн 49 дугаар зүйлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- (ж) Энэхүү гэрээний ажлыг гүйцэтгэхтэй холбоотой аливаа үйл ажиллагаанд авлига, хээл хахууль, залилан хийсэн нь холбогдох эрх бүхий байгууллагаар тогтоогдвол
- (з) Гүйцэтгэгчийн тухайн батлагдсан ажлын хуваарийн биелэлт нь 60%-аас бага бол гэрээ цуцлагдах үндэслэл болно.
- (и) Гүйцэтгэгч нь олгосон санхүүжилтийг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй тохиолдолд гэрээ цуцлагдах үндэслэл болно.
- (й) Гэрээт ажлыг зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй бол гэрээг цуцлан, тусгай зөвшөөрлийг нь цуцлах цаашид улсын чанартай ажлын сонгон шалгаруулалтад оролцох эрхийг түдгэлзүүлж хар жагсаалтад оруулах саналыг эрх бүхий байгууллагад тавих болно.

56.3 Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч ажлыг нэн даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**57 Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**

57.1 Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол Инженер зохих ёсоор хийж гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл төлөгдсөн урьдчилгаа төлбөр болон дуусаагүй ажлын хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Хэрэв Санхүүжүүлэгчид төлөх төлбөрийн нийт дүн Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь Гүйцэтгэгчээс Санхүүжүүлэгчид төлөх ёстой өр болно.

57.2 Гэрээг цуцалсан үед хийх төлбөр нь Захиалагчийн хүлээх хариуцлага болохгүй бөгөөд ГТН-д заасан байдлаар төлбөрийг хийнэ.

- 57.3 Гүйцэтгэгчийн дампуурал, татан буугдсанаас бусад үйл ажиллагаанаас шалтгаалан гэрээ хугацаанаас өмнө цуцлагдсан тохиолдолд гэрээ цуцлагдсанаас үүсэх аливаа хохирлыг гүйцэтгэгч хариуцна. Цаашид гэрээт ажил авах эрхийг тодорхой болон тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлнэ.
- 58 Өмч**
- 58.1 Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалж гэрээ цуцлагдсан бол ажлын талбай дээрх Санхүүжүүлэгчээс үнийг нь төлсөн бүх материал, байгууламж, тоног төхөөрөмж, туслах ажил болон ажлыг Санхүүжүүлэгчийн өмч гэж үзэн Санхүүжүүлэгчийн барьцаа хөрөнгө болгоно.
- 58.2 Гэрээний дагуу олж авсан гүйцэтгэгчийн оюуны өмч нь бүхэлдээ Санхүүжүүлэгчийн өмч байна.
- 58.3 **Гүйцэтгэгч** нь Санхүүжүүлэгчийг оюуны өмчийн маргаанаас хамгаалах мөн түүнээс гарсан аливаа зардал, нөхөн төлбөрийг өөрөө барагдуулах үүрэгтэй.
- 59 Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 59.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол Инженер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч нь уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг /Санхүүжүүлэгч/ улсын төсвөөс төлнө.

#### Е. БУСАД ЗААЛТ

- 60 Ашиг сонирхлын зөрчил**
- 60.1 Гэрээгээр зохицуулах харилцаанд оролцогч талууд нь ашиг сонирхлын зөрчилгүй байна. Гэрээний ажлыг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол талууд ажлаас түдгэлзэх эрхтэй.
- 61 Авлига, хээл хахууль**
- 61.1 Авлига, хээл хахуулийн талаар зохицуулсан Монгол Улсын хууль дүрмийг дагаж мөрдөх бөгөөд хууль зөрчсөн тохиолдолд гэрээг цуцална.
- 61.2 Гүйцэтгэгчийн авлига өгөх, авах, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах, эсвэл дарамт шахалт үзүүлэх үйлдэлд шууд эсхүл төлөөлөгчөөр дамжуулан холбогдсон тухай хангалттай нотолгоо бусад талуудад байгаа тохиолдолд гэрээг түдгэлзүүлж, холбогдох эрх бүхий байгууллагаар шалгуулна.
- 62. Гэрээний нууцлал**
- 62.1 Гүйцэтгэгч нь Санхүүжүүлэгч, Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр бүхий л бичиг баримт, тоо мэдээлэл, олж авсан болон цуглуулсан мэдээллээ ямар нэг байдлаар гэрээний үүргийг биелүүлэхээс бусад тохиолдолд олшруулах, нийтэд тараах, нийтлэх, задруулах эрхгүй.
- 62.2 Энэхүү үүргээ биелүүлээгүйгээс Захиалагчид ямар нэг хохирол учирсан тохиолдолд хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулна.


НУУЦ

62.3 Гэрээний ерөнхий нөхцөлийн 62 дугаар зүйлийн 62.2-т зааснаас гадна энэхүү гэрээг тендерт оролцох, банкны зээлд хамрагдах болон бусад зорилгоор олшруулж, хувилж нийтэд тараасан тохиолдолд Төрийн болон албаны нууцын тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээс гадна гэрээг шууд цуцлах үндэслэл болно

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН  
БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"УБТЗ" ХНН-ийн Замын 1-р орлогч дарга



...../МИЛОСТНЫХ И.В./

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"Вест-Энержи" ХХК-н захирал



...../А.ЭНХБАЯР/